

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө
оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн

АУДИТЫН КОД: /ГСА-2022/16-6-ШТА-ГА/

Говьсүмбэр аймаг
2022 оны 4 сар

Дарга, Тэргүүлэх аудитор Б.Сарантуяа

Утас: 7054-3156 Цахим шуудан: Sarantuyab@audit.gov.mn

Аудитын менежер Г.Наранбаяр

Утас: 7054-3179 Цахим шуудан: Naranbayarg@audit.gov.mn

Ахлах аудитор Б.Дарханбат

Утас: 7054-3179 Цахим шуудан: Darkhanbatb@audit.gov.mn

Аудитор С.Батцэцэг

Утас: 7054-3179 Цахим шуудан: BattsetsegSa@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хуудас: www.audit.mn

АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн: Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газар Дарга, Тэргүүлэх аудитор Б.Сарантуяа Аудитын менежер Г.Наранбаяр Ахлах аудитор Б.Дарханбат Аудитор С.Батцэцэг 2022 оны 04 дүгээр сар Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70543151 дугаарын утсаар харилцана уу. ХАЯГ: Аймгийн Засаг даргын тамгын газрын байр, 2 дугаар давхар, 209 тоот	Товчилсон үгийн тайлбар Бүлэг 1: Хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн тогтолцоо үр нөлөөтэй бус, бодлогын хэрэгжилт, үр дүн хангалтгүй байна. А.1 Хөрөнгө оруулалтыг үр ашигтай төлөвлөх бодлогын хэрэгжилт хангалтгүй, зохистой арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй байна..... 6 А.2 Төсөл, арга хэмжээг үр ашигтай төлөвлөх тогтолцоо бүрдээгүй, бодлогын хэрэгжилт үр дүнгүй байна. 9 Бүлэг 2: Худалдан авах ажиллагааны зарчим зөрчсөн, ил тод байдал, өрсөлдөөнийг хязгаарласан, төсөл, арга хэмжээнд тавих хяналт сул, хөрөнгө оруулалтаар бий болсон төсөл, арга хэмжээний чанар, ашиглалт хангалтгүй, үр дүнгүй байна. Б.1 Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулаагүй, худалдан авах ажиллагааны хуулийн зарчмыг зөрчсөн байна..... 12 Б.2 Захиалагч гэрээний хэрэгжилтийг хугацаанд нь бүрэн хангуулж, хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлээгүй байна. 14 Б.3 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилт үр дүнгүй байна. 16 Б.4 Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй, зөрчлийг давтан гаргасан байна..... 17 Дүгнэлт Зөвлөмж Холбогдох байгууллагын санал Холбогдох байгууллагын саналд хийсэн тайлбар Хавсралтууд
---	---

Товчилсон үгийн тайлбар

АДВОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ИТХХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдаан
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ОНТХО	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт
ЗДҮАХ	Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТАХ	Төсөл арга хэмжээ
ОНЕО	Орон нутгийн ерөнхий орлого
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

1. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд Улсын Их хурлын Төсвийн байнгын хорооны 2021 оны 06 дугаар тогтоол, “Аудитын төлөвлөгөө батлах тухай” Монгол Улсын Ерөнхий аудиторын 2022 оны А/12 дугаар тушаал, Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу хийлээ.

2. Аудитын зорилт:

Орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд Гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт, зөвлөмж гарган холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдсэн.

3. Аудитын хамарсан хүрээ:

Аудитад 2021 онд орон нутгийн төсвөөр хэрэгжүүлэхээр баталсан 12 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, хяналт тавих чиг үүрэг бүхий төрийн байгууллагуудын үйл ажиллагаа, холбогдох баримт материалуудыг хамрууллаа.

4. Аудитын арга зүй:

Аудитыг АДБОУС (INTOSAI)-ын хорооноос баталсан АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS6817-1:2020 “Төрийн аудит Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020 “Төрийн аудит Гүйцэтгэлийн аудит” стандартад заасан зарчим арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан ТАБ-аас аудит хийх журам, гүйцэтгэлийн аудит хийх аргачлалыг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг аудитын арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмжийг боловсрууллаа.

5. Аудит хийх багийн бүрэлдэхүүн:

Аудитыг дарга, Тэргүүлэх аудитор Б.Сарантуяа хянан удирдаж, үе шатны хяналтыг аудитын менежер Г.Наранбаяр хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Дарханбат, аудитор С.Батцэцэг нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ.

6. Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдах мэдээлэл

Аудитын тайлан нь аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж, холбогдох байгууллагын санал, түүнд хийсэн тайлбар, хавсралт гэсэн бүтцээр үндсэн зорилтын дагуу бичигдсэн.

7. Хүндрэл бэрхшээл

Бусад аудиттай аудитын хугацаа давхардаж хүний нөөцийн дутагдал үүссэн нь аудитад хүндрэл учруулж байлаа.

8. Үндсэн мэдээлэл

Аймгийн ИТХХ-ны 2021 оны 05 дугаар тогтоолд Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд шилжих 196.5 сая, шинээр 1,747.2 сая нийт 1,943.7 сая төгрөгийн төсөл арга хэмжээ, санхүүжүүлэхээр баталсан бөгөөд 1,471.7 сая төгрөгийн гэрээ байгуулсан байна

Аймгийн Орон нутгийн өмчийн газар нь 1,672.2 сая төгрөгийн 10 төсөл, арга хэмжээ, 80.2 сая төгрөгийн шилжих, 103.0 сая төгрөгийн шинээр хэрэгжих зураг төслийн ажлын худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар төлөвлөснөөс 1480.9 сая төгрөгийн 9 ажил, 121.0 сая төгрөгийн зураг төслийн ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг хүргүүлсэн байна.

Хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу нээлттэй тендер шалгаруулалт-7, харьцуулалтын аргаар 2, шууд гэрээ-4, зөвлөх үйлчилгээ-2^(АЗД-ын 2021 оны А/01 захирамжаар батлагдсан зураг төсвийн задаргаа) худалдан авах ажиллагааг зохион байгуулжээ.

Хөрөнгө оруулалтыг үр ашигтай төлөвлөх, зохистой арга хэмжээг авч байна уу?

Бүлэг А

Хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн тогтолцоо үр нөлөөтэй бус, бодлогын хэрэгжилт, үр дүн хангалтгүй байна.

А.1 Хөрөнгө оруулалтыг үр ашигтай төлөвлөх бодлогын хэрэгжилт хангалтгүй, зохистой арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй байна.

2021 оны Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөө нь аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй дараах байдалтай уялдсан байна.

Хүснэгт №1

Батлагдсан төсөл, арга хэмжээний тоо	Засаг даргын 2020-2024 үйл ажиллагааны хөтөлбөр		2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл	
	Нийцсэн	Нийцээгүй	Нийцсэн	Нийцээгүй
20	16	4	13	7

(Эх сурвалж: аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ-ийн мэдээ)

2021 оны орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр баталсан 20^(Зураг төсвийн задаргаа орсон) төсөл, арга хэмжээнээс аймгийн ЗДҮАХ-т 20 хувь, таван жилийн үндсэн чиглэлд 35 хувь нь тус тус нийцээгүй байна.

Дүрслэл 1**Хөтөлбөр, бодлогод нийцсэн арга хэмжээ**


1. Аймгийн төвийн гэрэлтүүлгийн ажил
2. Явган зам талбайн ажил
3. Сүмбэр сум 2-р баг, бичил цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилтын ажил
4. Нийтийн номын сангийн дээвэр засварын ажил
5. Сүмбэр сумын Засаг даргын Тамгын газрын их засварын ажил
6. Нийтийн эзэмшлийн байрнуудын цахилгааны цит, монтажийн засварын ажил
7. Ерөнхий боловсролын сургуулийн гал тогооны тоног төхөөрөмж худалдан авах ажил
8. 1 дүгээр сургуулийн гадна фасад, заалны дотор засварын ажлын зураг
9. Сүмбэр сумын 1 дүгээр багийн 2-р хэлхээний шугам сүлжээний өргөтгөлийн зураг
10. Халуун усны барилгын зураг төсөв
11. Найрамдал хотхон 1-р байрны гадна авто зогсоол байгуулах ажил
12. Мал эмнэлгийн газрын конторын барилгын ажил
13. Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажил
14. Усан бассейн бүхий спорт цогцолборын барилгын ажлын төсвийг шинэчлэх ажил
15. Сүмбэр сумын 1 дүгээр багийн бохир усны шугамын ажлын төсвийг шинэчлэх
16. Шивээговь сумын 3 дугаар цэцэрлэгийн өргөтгөлийн барилгын ажлын төсвийг шинэчлэх ажил

Хөтөлбөр, бодлогод нийцээгүй арга хэмжээ

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын контор, грашийн барилгын дээвэр засварын ажил
2. Цагдаагийн хэлтэс, Цаг уур орчны шинжилгээний газрын гадна шугам сүлжээ худалдан авах ажил
3. Ус-Ду ОНӨААТҮГ-ын зуухны их засварын ажилд шаардлагатай материал худалдан авах ажил
4. Найрамдал хотхоны цахилгаан хангамжийн ажлыг төсвийг шинэчлэх ажил
5. Сүмбэр сумын 1 дүгээр багийн 2-р хэлхээний шугам сүлжээний өргөтгөлийн зураг
6. Халуун усны барилгын зураг төсөв
7. Нийтийн эзэмшлийн байрнуудын цахилгааны цит, монтажийн засварын ажил

(Эх сурвалж: аймгийн 5 жилийн үндсэн чиглэл, үйл ажиллагааны хөтөлбөр)

ОНТХО-ын 2020 болон 2021 онд батлагдсан төсвийн хэмжээг харьцуулан графикаар харуулбал:




(Эх сурвалж: 2020, 2021 оны АИТХ-ын тогтоол)

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын дүн 2020 онд 1,664.0 сая төгрөг байсан бол 2021 онд 1,747.1 сая төгрөг болж өмнөх оноос 5 хувиар нэмэгджээ.

2021 онд шинээр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын 992.1 сая төгрөгийн 7 ажлыг аймгийн ИТХХ-ны 2020.12.04-ний өдрийн 03 дугаар тогтоолоор баталсан ба 2021.07.23-ны өдрийн 05 дугаар тогтоолоор тодотгол хийж, 1 ажил хасагдаж, 6 ажлын 768.1 сая төгрөгийн хөрөнгийг нэмж баталсан байна.

Шинээр хэрэгжих хөрөнгө оруулалтын ажлын задаргааг графикаар харуулбал:




Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 18% нь улсын төсвийн байгууллагуудад чиглэсэн байна.

Тайлант хугацаанд орон нутагт нэн тэргүүнд хэрэгцээ шаардлагатай байгаа төсөл, арга хэмжээний жагсаалтыг бэлтгээгүй байна.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 6.5.4¹, 6.5.5², Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10.2³, Сангийн сайдын 2019 оны 282 дугаарын тушаалын хавсралтаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 6 дугаар зүйлийн 6.4.2⁴, 6.4.3⁵, дахь заалтыг зөрчсөн, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй тул албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

Олон нийтийн хэрэгцээ шаардлагад нийцсэн ажлуудын жагсаалтыг графикаар харуулав.

Дүрслэл №2



(Эх сурвалж: 2020-2024 оны аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, 5 жилийн хөгжлийн үндсэн чиглэл)

ОНХО-аар 2021 онд хэрэгжүүлэхээр баталсан 1,747.2 сая төгрөгийн 12^(Зураг төсвийн задаргаа ороогүй) төсөл, арга хэмжээнээс 61 хувь буюу 1,064.4 сая төгрөгийн төсөл, арга хэмжээ нь иргэдийн эрүүл аюулгүй орчинд аж төрөх хэрэгцээ шаардлагыг хангахад чиглэжээ.

¹ 6.5.4 төрөөс үзүүлж байгаа аливаа ажил, үйлчилгээ, хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, тэдгээрийн хүрээнд худалдан авч байгаа бараа, ажил, үйлчилгээнд олон нийт хяналт тавих боломжоор хангах

² 6.5.5 хөтөлбөр, төсөл, арга хэмжээний ач холбогдлын эрэмбэ, хэрэгжүүлэх дараалал, арга замыг тодорхойлох шийдвэрт олон нийтийн саналыг харгалзан үзэх

³ 6.10.2 санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлсон, шаардлагатай хөрөнгө оруулалтын хэмжээг урьдчилан тооцсон, хариуцах эзэнтэй, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв нь батлагдсан, тухайн жилд хэрэгжүүлэх шаардлагатай төсөл, арга хэмжээг эрэмбэлсэн байх

⁴ Тухайн жилийн хөрөнгө оруулалтын бодлогын чиглэл, арга хэмжээний чиглэл

⁵ Хэрэгцээ шаардлага, үндэслэл

А.2 Төсөл, арга хэмжээг үр ашигтай төлөвлөх тогтолцоо бүрдээгүй, бодлогын хэрэгжилт үр дүнгүй байна.

Аймгийн ИТХХ-ны 2020 оны 03 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар шинээр 7 төсөл, арга хэмжээ, 2021 оны 05 дугаар тогтоолоор 6 төсөл, арга хэмжээг нэмж 1 төсөл арга хэмжээг хасаж 12^(Зураг төсвийн задаргаа ороогүй) төсөл, арга хэмжээнд 1,747.2 сая, шилжих төсөл, арга хэмжээнд 196.5 сая нийт 1,943.7 сая төгрөгийн санхүүжилт олгохоор баталсан байна.

Мөн 2020 онд 140.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Талын илч ОНӨААТҮГ-т зуух худалдан авч суурилуулах ажил”-ын 30.0 сая, “Чойр хийдийн дуганы гадна, дотор засварын ажил”-ын 24.3 сая нийт зарцуулаагүй үлдэгдлийг барьцаа дансанд төвлөрүүлсэн 54.3 сая төгрөг зарцуулаагүй үлдэгдлийг барьцаа дансанд байршуулсан ба тайлант онд 45.2 сая төгрөгийн санхүүжилт олгожээ.

2021 онд хийгдэх ажлуудын зураг төсвийн зардалд 100.0 сая төгрөг баталсан бөгөөд аймгийн Засаг даргын 2021 оны А/01 дүгээр захирамжаар 6, 2021 оны А/300 дугаар захирамжаар 3 нэмэгдэж, нийт 9 зураг төсвийн задаргааг баталжээ.

Зураг төсвийн ажлын даалгаврыг хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагын дагуу боловсруулсан боловч зураг төсвүүдийн гэрээ нь хугацаандаа хийгдээгүй, 2-3 удаагийн гэрээний сунгалт хийгдэж цаг хугацаа алдсан байна.

Зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмын дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулсан 1, шууд гэрээ байгуулсан 4, хэрэгжээгүй 4, нийт 9 зураг төсвийн ажлаас 2 зураг төсөв нь хугацаандаа хийгдэж, 3 нь он дамжиж, 4 нь гэрээ байгуулагдаагүй, зарим ажлын даалгаврыг цаг хугацаанд нь гаргасан боловч гүйцэтгэгч болон захиаллагчтай холбоотой, Ковид 19-ээс шалтгаалж хугацаа алдсан байна.

Ажлын даалгавар батлагдсан болон тендер зарласан хугацааг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №2						
№	Төсөл, арга хэмжээний нэр	АИТХХ-ны тогтоолын огноо	Засаг даргын захирамжийн огноо	Ажлын даалгавар батлагдсан огноо	Тогтоол батлагдсанаас хойш алдсан хугацаа/хоног/	Захирамж батлагдсанаас хойш алдсан хугацаа/хоног/
1	Мал эмнэлгийн газрын конторын барилгын ажлын зураг төсөв			2021.03.03	89	54
2	Сүмбэр сумын 1 дүгээр багийн 2-р хэлхээний шугам сүлжээний өргөтгөлийн зураг	2020.12.04	2021.01.08	2021.09.15	289	247

(Эх сурвалж: аймгийн ОНӨГ-ын судалгаа)

Зураг төсвийн ажлыг тухайн ондоо багтааж хийгээгүйгээс хөрөнгө оруулалтын дараа жилийн төлөвлөлтөд сөргөөр нөлөөлж, 2022 онд хийгдэх хөрөнгө оруулалтын ажлууд хугацаа алдах, төлөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээ аймгийн ИТХХ-аар батлагдах нөхцөл байдал үүссэн байна. Тухайлбал:

- “Сүмбэр сум 2-р баг, бичил цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилтын ажил”-ын зураг төсөл, төсөв нь магадлалаар хянагдаж баталгаажуулаагүй байхад 2021 оны төсөвт тусган тендер шалгаруулалт зарласан.
- “Сүмбэр сумын 1 дүгээр багт дахин төлөвлөлт хэрэгжүүлэх байршилд ерөнхий төлөвлөгөөний зураг”-ийн ажлын техникийн нөхцөлийг олгоогүй.
- “Халуун усны барилгын ажлын зураг төсөв боловсруулах ажил”-ын газрын захирамж гараагүй зэрэг шалтгаанаар гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг 4 удаа буюу 252 хоногоор

хугацааг сунгаж, урьдчилгаа төлбөрийн 50 хувь 4.0 сая төгрөг олгосон боловч хугацаандаа ажлаа гүйцэтгээгүй.


Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3⁶, 29 дүгээр зүйлийн 29.4⁷, Барилгын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.4⁸, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4⁹, 8.5¹⁰, 8.7.1¹¹, 46 дугаар зүйлийн 46.1.5¹²-т, 46.1.8¹³-т, Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан. “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.4¹⁴-т заасныг тус тус зөрчсөн тул албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

2021 онд ИТХХ-ны 05 дугаар тогтоолоор шинээр 12 төсөл, арга хэмжээг баталсан бөгөөд тайлант онд 8 ажлыг хүлээн авсан байна.

Шинээр хүлээн авсан ажлын жагсаалтыг харуулбал:

График 3

(сая төгрөг)



(Эх сурвалж: аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ-ийн судалгаа)

Тайлант онд төлөвлөсөн хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэл 66.6 хувьтай буюу зорилтот түвшиндээ хүрч ажиллаагүй байна.

Тайлант онд хэрэгжээгүй он дамжсан дараах ажлууд байна. Үүнд:

1. Аймгийн ИТХХ-ны 2020 оны 03 дугаар тогтоолоор баталсан “Сүмбэр сумын 2-р баг бичил цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилт”-ын ажлын 379.2 сая төгрөгийн

⁶ 14.2.3 өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах

⁷ 29.4 Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

⁸ 25.4 Энэ хуулийн 25.2, 25.3-т заасан зураг төсөлд магадлал хийлгээгүй бол барилгын ажлын зөвшөөрөл олгохыг хориглоно.

⁹ 8.4 “Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно”,

¹⁰ 8.5 “Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно”,

¹¹ 8.7.1 “тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо бүх багцын нийлбэр өртгийг үндэслэл болгох”,

¹² энэ хуулийн 7.6-д зааснаас бусад бараа, ажил, үйлчилгээг санхүүжүүлэх хөрөнгийн эх үүсвэр батлагдсаны дараа худалдан авах ажиллагааг эхлүүлэх

¹³ 46.1.5 барилга, зам, инженерийн шугам сүлжээ зэрэг тодорхой улиралд гүйцэтгэх онцлог шинж чанартай бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааг тухайн жилийн төсөв батлагдсан даруйд эхлүүлэх

¹⁴ 46.1.8 Төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн багцад тухайн жилд батлагдсан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг хангаж ажиллана

төсөвт өртгийг аймгийн ИТХХ-ны 2021 оны 04 дүгээр хуралдааны 05 дугаар тогтоолоор 60.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 439.2 сая төгрөг болгон баталсан бөгөөд гүйцэтгэгчээр “Хүслэн хийморь” ХХК шалгарч, 2021 оны 12 дугаар сарын 14-нд гэрээ байгуулсан тул тухайн ажил төлөвлөсөн хугацаанд хэрэгжих боломжгүй болж дараа онд шилжсэн:

2. “Аймгийн төвийн гэрэлтүүлгийн ажил” улсын чанартай авто замын дагуу гэрэлтүүлгийн ажил хийх тул зөвшөөрөл аваагүй шалтгаанаар ажил удааширч дараа онд шилжсэн.
3. “Нийтийн эзэмшлийн байрнуудын цахилгааны щит, монтажийн засварын ажил” нь гүйцэтгэгчийн үйл ажиллагаанаас шалтгаалж дараа онд шилжсэн.
4. 100.0 сая төгрөгийн 9 зураг төсвийн ажлыг гүйцэтгэхээр төлөвлөсөн боловч 62.3 сая төгрөгийн 5 ажлын зураг төсвийн гэрээг байгуулж, 32.1 сая төгрөгийн санхүүжилтийг олгож, 28.0 сая төгрөгийн 2 ажлын зураг төсвийг хүлээн авч санхүүжилтийг олгосон бол 2 ажлын зураг төсвийн урьдчилгаа санхүүжилтэд 4.1 сая төгрөгийг олгож, 1 ажлын зураг гүйцэтгэгч урьдчилгааны хүсэлтийг ирүүлээгүй тул олгоогүй байна.

Б. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт үр дүнтэй байна уу?**Бүлэг Б**

Худалдан авах ажиллагааны зарчим зөрчсөн, ил тод байдал, өрсөлдөөнийг хязгаарласан, төсөл, арга хэмжээнд тавих хяналт сул, хөрөнгө оруулалтаар бий болсон төсөл, арга хэмжээний чанар, ашиглалт хангалтгүй, үр дүнгүй байна.

Б.1 Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулаагүй, худалдан авах ажиллагааны хуулийн зарчмыг зөрчсөн байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ажлын 10, зураг төсвийн 2 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны гишүүдийг аймгийн Засаг даргын захирамжаар томилсон байна.


Давхардсан тоогоор 60 төрийн албан хаагч болон хөндлөнгийн төлөөллийг оролцуулан үнэлгээний хороог байгуулсан бөгөөд үнэлгээний хорооны гишүүд нь худалдан авах ажиллагааны АЗ эрхийн гэрчилгээтэй энэ чиглэлээр сургалтад хамрагдаж мэргэшсэн байна.

Аймгийн Орон нутгийн өмчийн газар нь аймгийн Засаг дарга буюу ТЭЗ-аас баталсан худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 18^(Зураг төсвийн задаргаа орсон) төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.

Үнэлгээний хороо нь төсөл, арга хэмжээг Сангийн сайдын баталсан жишиг баримт бичгийн дагуу тендерийн баримт бичгийг боловсруулж, захиалагчаар батлуулсан байна.

Тендер сонгон шалгаруулалтыг графикаар харуулбал:

График №4



(Эх сурвалж: аймгийн ОНӨГ-ын судалгаа, аймгийн ЗД-ын 2021 А/01 тоот захирамжаар баталсан зураг төсвийн задаргаа болон тендер шалгаруулалт зарласан боловч амжилтгүй болсон төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа орсон)

Аймгийн ИТХХ-ны 2020 оны 03 дугаар тогтоолын 03 дугаар хавсралтаар 2021 онд хийгдэх ажлуудын зураг төсвийн зардалд 100.0 сая төгрөг баталсан боловч 2 ажлын зураг хасагдсан, 62.3 сая төгрөгийн худалдан авах ажиллагааг батлагдсан төсвийн дүнгээр зарлаагүй байна.

“Цагдаагийн хэлтэс, Цаг уур орчны шинжилгээний газрын гадна шугам сүлжээ худалдан авах” ажлыг захиалагчаас ирүүлсэн хүсэлтийг дагуу нээлттэй тендер

шалгаруулалт явуулсан боловч 2 удаа амжилтгүй болж, Орон нутгийн өмчийн газраас шууд гэрээ байгуулах зөвлөмжийг захиалагчид олгосон байна.

Худалдан авах ажиллагаа нь нээлттэй тендер шалгаруулалтын зарчмаар явагдсан боловч худалдан авах ажиллагааны зарчмыг зөрчсөн байна. Тухайлбал:

1. Гүйцэтгэгч болох “Грийн радианс” ХХК тендерийн баримт бичигт заасан шалгуур үзүүлэлтийг хангаагүй байхад гэрээ байгуулсан
2. “Грийн радианс” ХХК-нийн гүйцэтгэсэн шугамын ажил магадлалаар баталгаажсан зураг төсөл, төсөвгүй.
3. Шугам сүлжээг ашиглалтад хүлээн авах улсын комиссын актгүй.
4. Зураг төсөл нь магадлалаар баталгаажих боломжгүй шалтгаанаар хяналтын төсвийг бэлтгээгүй, төсөвт өртгийг баталгаажуулахгүйгээр, 2 жил ашигласан шугамыг үнэлгээ хийлгүйгээр ашигласан жилийн элэгдэл хорогдлыг тооцолгүйгээр батлагдсан төсөвт тулган 320.0 сая төгрөгөөр худалдан авахаар шууд гэрээ байгуулсан.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2¹⁵, Барилгын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1¹⁶, 25.2.5¹⁷, Барилга хот байгуулалтын сайдын 2012 оны 181 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Барилгын үнэ бүрдлийн үндсэн дүрэм”-ийн 5.22. III.¹⁸, 6.59¹⁹-д заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 35 дугаар зүйл, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2021 оны А/69 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”-ын 2.2.3²⁰-д заасны дагуу уг асуудлыг хуулийн байгууллагад шилжүүлэхээр шийдвэрлэв.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн 12 төсөл, арга хэмжээний тендер сонгон шалгаруулалтыг аймгийн ОНӨГ-аас цахимаар зарлаж, тендер шалгаруулалтын үр дүнг цахим хуудсанд нийтэлсэн байна.

Захиалагч нь шууд гэрээ байгуулсан төсөл, арга хэмжээний гэрээний хувийг үндэслэлийн хамт Сангийн яаманд хүргүүлэх үүргээ биелүүлээгүй, Зураг төсвийн ажлыг батлагдсан төсвийн дүнгээр тендер шалгаруулалт явуулахгүйгээр жижиглэн шууд гэрээ байгуулж байгаа нь ашиг сонирхлын зөрчил үүсэх, ил тод байдлыг хангахгүй байх, өрсөлдөөнийг хязгаарлах үр дагавартай байна.

¹⁵ 34.2.Энэ хуулийн 34.1-д заасан нөхцөлийн дагуу шууд гэрээ байгуулахад захиалагч энэ хуулийн 14-16 дугаар зүйлийн шаардлагыг хангасан, тухайн бараа, ажил, үйлчилгээг гүйцэтгэх чадавхитай нэг, эсхүл түүнээс дээш тооны этгээдтэй хэлэлцээ хийж, техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл, шаардлагыг хамгийн сайн хангасан этгээдтэй энэ хуульд заасны дагуу гэрээ байгуулах бөгөөд хэлэлцээний үед хүрсэн аливаа тохиролцоог гэрээнд тусгана.

¹⁶ 24.1.1.батлагдсан зураг төсөлд үндэслэсэн байх;

¹⁷ 25.2.5.энэ хуулийн 10.1.2, 10.1.3-т заасан ангилалд хамаарах улс, орон нутгийн төсөв, гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр барих барилга, байгууламжийн төсөв, нэгдсэн төсөв.

25.4.Энэ хуулийн 25.2, 25.3-т заасан зураг төсөлд магадлал хийлгээгүй бол барилгын ажлын зөвшөөрөл олгохыг хориглоно.

¹⁸ Ажил гүйцэтгэх технологи болон ашиглах материалын төрлөөр бүлэглэгдсэн өртгийн норматив үзүүлэлт нь төсвийн тооцоог бүрэн гүйцэд хийх боломж олгоно. Барилга байгууламжийн өртгийн тооцоог томсгосон норм, үнэлгээг үндэслэн захиалагч гүйцэтгэнэ. Энэхүү хяналтын төсөв нь барилгын гүйцэтгэгч байгууллагыг сонгон шалгаруулах үндэслэл болно.

¹⁹ 6.59. Барилгын ажлын гэрээний үнэ тохиролцох, гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтад дараах зарчмыг баримтлана. Үүнд: Хяналтын төсвийг үндэслэн гүйцэтгэгчийн үнийн саналд шүүлт хийж үнэлэлт, дүгнэлт өгөх

²⁰ 2.2.3 Мэргэжлийн үнэлэмж ба үл итгэх үзэл-Хэрвээ аудитор залиланг сэжиглэх, залилантай тулгарвал асуудлыг хянан удирдагчид хэлж дараагийн арга хэмжээ авах, холбогдох эрх мэдэлтнүүдийн анхааралд оруулах хэрэгтэй

Б.2 Захиалагч гэрээний хэрэгжилтийг хугацаанд нь бүрэн хангуулаагүй, хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлээгүй байна.

Аудитаар хөрөнгө оруулалтын 9 төсөл, арга хэмжээг зураг төсөв, техникийн тодорхойлолтын дагуу гүйцэтгэсэн эсэхийг шалгахад 98.9 сая төгрөгийн дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. “Цагдаагийн хэлтэс, цаг уур орчны шинжилгээний газрын гаднах шугам сүлжээг худалдан авах ажил”-ын техникийн тодорхойлолт, ажлын тоо хэмжээнд тусгасан ажлууд хийгдээгүй байхад хүлээн авсан.
2. “Нийтийн эзэмшлийн байрнуудын цахилгааны щит, монтажийн засварын ажил”-ыг 89.8 сая төгрөгөөр “Хайрхан бар” ХХК гүйцэтгэхээр гэрээ байгуулсан. Уг ажлын гэрээний хугацааг 2 удаа сунгасан боловч ажлын гүйцэтгэл хангалтгүй, гэрээний хугацаа дууссан боловч алданги тооцоогүй байна.
3. “Халуун усны барилгын ажил”-ын зураг төсвийг “Баяр мега сервис” ХХК 8.0 сая төгрөгөөр гүйцэтгэхээр гэрээ байгуулсан боловч газрын зөвшөөрөл гараагүйгээс ажил удааширсан, гэрээний хугацааг 2 удаа сунгасан боловч хугацаандаа гүйцэтгээгүй, алданги тооцоогүй
4. “Сүмбэр сумын 2 дугаар багийн тоглоомын талбай”-н ажлын магадлалаар баталгаажсан зураг төсөв, төслийг нь 2021 оны 5 дугаар сарын 31-нд хүлээн авсан бөгөөд 2021 оны хөрөнгө оруулалтын төсөвт баталгаажсан зураг төсөл, төсөвгүйгээр тусгагдсан.

Уг ажлыг 2021 оны 7 дугаар сард “Чинбат” ХХК-тай 371.6 сая төгрөгийн гэрээ байгуулан гүйцэтгүүлэхээр болсон боловч ажлын даалгавар, зураг тодорхойгүй, тоо хэмжээнээс илүү нэмэлт ажлыг гүйцэтгэх шаардлагыг захиалагч тавьсан шалтгаанаар тухайн ажлаас татгалзсан байна. АИТХХ-ны 2021 оны 05 дугаар тогтоолоор дээрх ажлын тухайн жилд санхүүжих дүнг 60.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж, ХАА-г дахин зарласан бөгөөд 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдөр “Хүслэн хийморь” ХХК-тай 433.2 сая төгрөгийн гэрээг байгуулсан байна.

5. Өмнөх оноос дамжсан “Сүмбэр сумын 1 дүгээр багт дахин төлөвлөлт хэрэгжүүлэх байршилд ерөнхий төлөвлөгөөний зураг”-ийн ажлыг 18.4 сая төгрөгөөр “Жаргалант хийц” ХХК гүйцэтгэхээр гэрээ байгуулсан боловч захиалагч техникийн нөхцөлийг олгоогүй, ковид-19-тэй холбоотойгоор гэрээний хугацааг 4 удаа сунгасан боловч хугацаандаа гүйцэтгээгүй, алданги тооцоогүй.
6. Өмнөх оноос дамжсан “Чойр хийдийн дуганы гадна, дотор засварын ажил”-ыг гүйцэтгэгч “Эхлэл шинэчлэлт прожект” ХХК ковид-19 цар тахлын улмаас гэрээний хугацааг 1 удаа сунгасан боловч хугацаандаа гүйцэтгээгүй, сийлбэрийн ажлуудыг техникийн нөхцөлд заасан аргаар гүйцэтгээгүй, дутуу чанаргүй хийсэн, шал хөндийрсөн, хана таазны замаск, эмульс ховхорч унасан, ажлын гүйцэтгэл чанаргүй байна.

Говьсүмбэр аймагт 2021 онд хийгдэх барилга байгууламж, барилгын засварын ажилд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэх гэрээг аймгийн ЗДТГ болон ГХБХБГ-ын хооронд байгуулсан байна.

Гэрээний хавсралтаар орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 1,342.9 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий өмнөх оноос дамжсан 2, тайлант онд шинээр хэрэгжих 7 төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналтыг хийхээр баталсан.

Тайлант онд захиалагчаас хяналтыг хэрэгжүүлэхээр 6.3 сая төгрөгийн хяналтын зардлыг авч, зарцуулсан байна.

Гүйцэтгэлээр 5 ажилд захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн бөгөөд дараах 4 төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавиагүй байна. Үүнд:

- “Аймгийн төвийн гэрэлтүүлгийн ажил”, “Сүмбэр сумын 2-р баг, бичил цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилтын ажил”, “Нийтийн эзэмшлийн байрнуудын цахилгааны щит, монтажийн засварын ажил”, өмнөх оноос дамжсан “Чойр хийдийн дуганы гадна, дотор засварын ажил”

Эдгээрээс “Сүмбэр сумын 2-р баг, бичил цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилтын ажил” худалдан авах ажиллагаанаас шалтгаалан он дамжсан тул хяналт тавих боломжгүй байсан байна.

Дараах 2 ажилд захиалагч үе шатны хяналтыг хэрэгжүүлэхгүйгээр ажлын гүйцэтгэлийг баталгаажуулсан байна. Үүнд:

- “Нийтийн эзэмшлийн байрнуудын цахилгааны щит, монтажийн засварын ажил”-д явцын хяналт хийгээгүй боловч ажлын гүйцэтгэлийг 80.5 хувиар баталгаажуулж, 70.5 сая төгрөгийн санхүүжилт олгосон.
- Өмнөх оноос дамжсан “Чойр хийдийн дуганы гадна, дотор засварын ажил”-д явцын хяналт хийгээгүй боловч 70 хувиар баталгаажуулж, 15.2 сая төгрөгийн санхүүжилт олгосон.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1²¹ 14 дүгээр зүйлийн 14.2.3²², Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.6²³, Иргэний хуулийн 232 дугаар зүйлийн 232.6²⁴, 350 дугаар зүйл 350.1.1²⁵, 351.1.4²⁶, Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.4²⁷, 15 дугаар зүйлийн 15.3²⁸, захиалагч гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээнд заасныг зөрчсөн тул зөрчлийг арилгах албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

Захиалагчийн хяналтаар өгсөн зөвлөмж, түүний хэрэгжилтийн байдал, хүлээн авсан хяналтын зардлыг хүснэгтээр харуулбал:

²¹ 6.4.1 “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах

²² 14.2.3 “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах

²³ гүйцэтгэгчийн гэрээний үүргийн биелэлтэд чанар болон гүйцэтгэлийн хяналт тавьж, явцын мэдээллийг хагас жил тутам худалдан авах ажиллагааны цахим системд оруулах

²⁴ Хууль болон гэрээнд заасан хугацаа хэтрүүлсэн тал нь хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0,5 хувиас хэтрэхгүй хэмжээгээр төлөхөөр тогтоосон анзыг алданги гэнэ

²⁵ 350.1.1 “гэрээнд заасан ажлыг тогтоосон хугацаанд гүйцэтгэх”

²⁶ 350.1.4 “ажил гүйцэтгэгчийн тавьсан шаардлагын дагуу чанар муутай буюу шаардлага хангахгүй материалыг сольж өгөх, буруу зааварчилгаагаа өөрчлөх, ажлын чанар, үр дүнд муугаар нөлөөлөх бусад нөхцөл байдлыг арилгах талаар өөрөөс шалтгаалах бүхий л арга хэмжээ авах.”

²⁷ 9.4 Санхүүжилтийн гүйцэтгэлийг тухайн төсөл, арга хэмжээний зураг төсөл болон төсвийн дагуу барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийг үндэслэн барилга угсралтын гэрээнд тусгасан үе шатны ажил тус бүрээр гаргаж магадлалар баталгаажсан зураг төсөл болон төсөвтэй тулгаж, хянан баталгаажуулна.

²⁸ 15.3 Захиалагч нь барилга байгууламжийн ажлын үе шат бүрт зохиогчоор хяналт тавиулж, дүгнэлт гаргуулна.

Хүснэгт: 3

(сая төгрөг)

№	Төсөл, арга хэмжээний нэр	Хяналтаар өгсөн зөрчил арилгах зөвлөмжийн тоо	Хэрэгжилтийн байдал	Хүлээн авсан хяналтын зардлын дүн
1	Явган зам талбайн ажил	3	3	1.96
2	Найрамдал хотхон 1-р байрны гадна авто зогсоол байгуулах ажил	4	4	1.48
3	Нийтийн номын сангийн дээвэр засварын ажил	1	1	0.18
4	Аймгийн Засаг даргын Тамгын газрын контор, грашийн барилгын дээвэр засварын ажил	2	2	1.64
5	Талын Илч ОНӨААТҮГ-т зуух худалдан авч суурилуулах ажил	1	1	1.05
Нийт		11	11	6.31

(Эх сурвалж: ГХБХБГ-ын захиалагчийн хяналтын тайлан)

Б.3 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн олгоогүй байна.

Тайлант хугацаанд шинээр 12 төсөл, арга хэмжээнд 1,473.1 сая төгрөгийн гэрээ байгуулсан байна.

2021 онд гэрээ байгуулсан ажлын санхүүжилтэд 914.7 сая, өмнөх оноос дамжсан ажлын санхүүжилтэд хөрөнгө оруулалтын данснаас 173.4 сая, барьцаа данснаас 45.2 сая нийт 1,133.1 сая төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэгч болон барьцаа хөрөнгийн дансанд шилжүүлжээ. Үүнээс дараах ажлын санхүүжилтийг олгохдоо бодит гүйцэтгэлд үндэслэн олгоогүй байна.

- “Мал эмнэлгийн газрын конторын барилга угсралтын зураг төсөв боловсруулах ажил”-ын магадлалын дүгнэлт гараагүй байхад гэрээний дүн 20.0 сая төгрөгийг бүрэн олгосон.
- “Цагдаагийн хэлтэс, Цаг уур орчны шинжилгээний газрын гадна шугам сүлжээ худалдан авах ажил”-д техникийн тодорхойлолт, тоо хэмжээнд заасан ажлууд хийгдээгүй байхад гэрээний санхүүжилт 320.0 сая төгрөгийг бүрэн олгосон

Тайлант онд хэрэгжиж дуусаагүй он дамжсан ажлыг харуулбал:

Хүснэгт №4

(сая төгрөг)

Он дамжсан төсөл арга хэмжээний нэр	Төсөвт өртгийн дүн /сая.төгрөг/
Аймгийн төвийн гэрэлтүүлгийн ажил	72.64
ОНЕО-д үлдэгдлээр төвлөрүүлсэн.	
Сүмбэр сумын 1 дүгээр багийн 2-р хэлхээний шугам сүлжээний өргөтгөлийн зураг	25.00
ОНЕО-д үлдэгдлээр төвлөрүүлсэн.	
Халуун усны барилгын зураг	4.00
ОНЕО-д үлдэгдлээр төвлөрүүлсэн.	
Сүмбэр сумын 2-р багийн бичил цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилтын ажил	433.22
ОНЕО-д үлдэгдлээр төвлөрүүлсэн.	

Нийтийн эзэмшлийн байрнуудын цахилгаан щит, монтажийн засварын ажил	19.40
ОНЕО-д үлдэгдлээр төвлөрүүлсэн. Сүмбэр сумын 1 багийн дахин төлөвлөлт хэрэгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний зураг	9.2
ОНЕО-д үлдэгдлээр төвлөрүүлсэн.	
Нийт	563.46


(Эх сурвалж: аймгийн АЗДТГ-ын ХБТХОХ-ийн судалгаа)

Улсын комисс ажиллаж ашиглалтад хүлээн авсан хөрөнгийг ашиглагч байгууллагуудын бүртгэл тайлагнал, ашиглалтын байдалд шалгалт хийхэд нийт 899.2 сая төгрөгийн хөрөнгийг аймгийн ИТХХ-ийн 2021 оны 20, 46 дугаар тогтоолоор ашиглагч байгууллагууд данс бүртгэлд бүрэн тусгасан байна.

Ашиглагч байгууллагад бүртгэсэн хөрөнгийн жагсаалтаар харуулав.

График № 6

/сая төгрөг/



(Эх сурвалж: АИТХ-ын 2021 оны 20,46 дугаар тогтоол)

Б.4 Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй, зөрчлийг давтан гаргасан байна.

Өмнөх аудитаар нийт 303.3 сая төгрөгийн 11 алдаа, зөрчил илрүүлж, алдаа зөрчлийг арилгах 150.0 сая төгрөгийн 2 зөрчилд албан шаардлага, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 153.3 сая төгрөгийн 9 зөвлөмж өгсөн бөгөөд хэрэгжилтийг дахин тооцоход дараах зөрчлүүд давтагдан гарсан байна. Үүнд:

1. Хөрөнгө оруулалтын төлөвлөлттэй холбоотой

- Аймгийн хэмжээнд хөрөнгө оруулалтаар хийгдэх шаардлагатай ажлын жагсаалтыг гаргаж, ач холбогдлоор нь эрэмбэлж, дунд хугацааны бодлогын бичиг баримтуудтай уялдуулан төсөл, арга хэмжээний үр ашиг, үр нөлөөг тооцож төлөвлөх, төлөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг төлөвлөхгүй байх гэсэн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй.

2. Худалдан авах ажиллагаатай холбоотой

- Аймгийн ИТХ-аар төсөв батлуулахдаа зураг төсвийн жагсаалтыг хамтад нь батлуулах, зураг төсвийн ажлын даалгаврыг тухайн жилийн төсөв батлагдсан

даруй боловсруулж, худалдан авах ажиллагааг эхлүүлэх, Үнэлгээний хорооны баримт бичгийг тухай бүр үйлдэж гарын үсгээр баталгаажуулах зөвлөмжийг хэрэгжүүлээгүй.

- Хөрөнгө оруулалтын ажлын зураг төсвийг нийт батлагдсан төсвийн дүнгээр багцлан зарлах албан шаардлага хэрэгжээгүй.

3. Захиалагчийн хяналттай холбоотой

- Барилгын ажлын үе шат бүрд хийсэн хяналтын тайланг тухай бүр гаргаж хэвших, баримтжуулах, нотлох баримтын бүрдлийг хангах, захиалагчийн хяналтын гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлэх зөвлөмжийг хэрэгжүүлээгүй.

4. Хөрөнгө оруулалтын үр өгөөжтэй холбоотой

- “Сүмбэр сумын Найрамдал хотхоны бохирын өргөх станцын өргөтгөлийн ажил”, “Чойр хийдийн дуганы гадна, дотор засварын ажил” технологийн шийдлийг оновчтой гаргаж, ашиглалтын хэвийн нөхцөлд оруулах, гэрээний хугацаанд ажлыг гүйцэтгүүлэх албан шаардлага хэрэгжээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1²⁹, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А95 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.2³⁰-т заасны дагуу өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг биелүүлээгүй зөрчлийг давтан гаргасан захиалагч буюу аймгийн ЗДТГ-ын даргад хариуцлага тооцуулах албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

Гүйцэтгэлийн аудитаар нийт 438.9 сая төгрөгийн 6 алдаа, зөрчил илрүүлж, зөрчлийг арилгах 1 зөвлөмж, 118.9 сая төгрөгийн 4 зөрчилд албан шаардлага, 320.0 сая төгрөгийн 1 зөрчлийг хуулийн байгууллагад шилжүүлэхээр шийдвэрлэв.

²⁹ 42.1. Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно.

³⁰ Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд “Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага” хүргүүлнэ.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна.

Бүлэг-А

1. Хөрөнгө оруулалтыг үр ашигтай, зохистой төлөвлөх арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй байна.
2. Төсөл, арга хэмжээг үр ашигтай төлөвлөх тогтолцоо бүрдээгүй, бодлогын хэрэгжилт үр дүнгүй байна.

Бүлэг-Б

1. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулаагүй, худалдан авах ажиллагааны хуулийн зарчмыг зөрчсөн байна.
2. Захиалагч гэрээний хэрэгжилтийг хугацаанд нь бүрэн хангуулаагүй, хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлээгүй байна.
3. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн олгоогүй байна.
4. Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй, зөрчлийг давтан гаргасан байна.

.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг зөвлөж байна.
Үүнд:

Аймгийн ТЕЗ бөгөөд Засаг даргад

1. Хөрөнгө оруулалтаар хийгдэж буй ажлуудын чанарын асуудалд онцгой анхаарах, хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон барилга байгууламж, тоног төхөөрөмжийн ашиглалтыг сайжруулж, үр өгөөжийг нэмэгдүүлэх, аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагыг биелүүлэх арга хэмжээ авч ажиллах

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг,
Найрамдал хотхон, Утас/Факс: (976) 7054 3118,
И-мэйл: zdtg.gaa@gmail.com, Вэбсайт: www.govisumber.gov.mn

2022.08.04 № 01/692
төсвийн 2022.08.02-ны № 956-т


ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Аймгийн "Орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн"-д хийсэн Гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцаж дараах тайлбар, саналыг хүргүүлж байна.

Хавсралт 4 хуудастай.

ДАРГА  Д.СОДНОМ



А/а Т.Даргаанбаатар
Найрамдал хотхон, Санхүүжилт
Төсвийн аж, Тайлангаа
Хүргэлэн баталгаа -
нууцгаа


1. Аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 04-ны өдрийн 03 дугаар тогтоолоор Аймгийг 2021 онд хөгжүүлэх үйл ажиллагааг 2021 оны төсвөөр батлуулан, хэрэгжүүлж ажилласан. Төлөвлөсөн арга хэмжээг бодлогын баримт бичигтэй тулгалт хийхэд бүрэн нийцэж байна.
2. 2020 оны үйл ажиллагаанд аудитын дүгнэлт хийлгэж 2021 оны 3 дугаар сард ирүүлсэн зөвлөмжийг 2022 оны төсвийн тодотголоор хэрэгжүүлж нийт ажлын зураг төсвийг задалж батлуулсан. 2021 оны төсөв батлуулсны хойно зөвлөмж ирсэн тул тухайн үед хэрэгжүүлэх боломжгүй байсан.
3. Орон нутгийн төрийн захиргааны байгууллагуудаас тавьсан хүсэлтийн дагуу ОБГ, Цагдаагийн хэлтсийг дулаанаар хангах зорилгоор 2020 онд хувийн хэвшлийн байгууллагаас ашиглалтад оруулсан шугам худалдан авах төсөв 2021 оны тодотголоор батлагдан ирсэн. Аймгийн ЗДТГ-аас шугамын ажлын тоо хэмжээг авч хяналтын төсөв хийлгэж, хууль журмын дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулсан. Нээлттэй тендер шалгаруулалтыг 2 удаа зарласан боловч худалдах байгууллага орж ирээгүй учир үнэлгээний хорооны өгсөн зөвлөмжийн дагуу шууд гэрээ байгуулж ажилласан. Техникийн баримт бичигт ШШАлбанаас тавьсан саналыг шийдвэрлэхээр техникийн тодорхойлолтод нэмэлт ажлуудыг оруулж, нийлүүлэгч, ШШАлба хоёр хэрэгжүүлж ажилласан. Хууль зөрчсөн ямар нэг ажиллагаа байхгүй болно.
4. 2021 оны зөрчилтэй гэх төсөл арга хэмжээ нь тухайн цаг үеийн ковидын нөхцөл байдал, хөл хорио, ачаа тээврийн зогсолт, гүйцэтгэгч компанид гарсан хүндрэл зэрэг шалтгаанаар гэрээг сунгаж ажилласан. Мөн УБТЗ-ын ЦТС, БЗӨБЦТС ТӨХК-д холбогдох техникийн нөхцөлийг авах хүсэлтийг удаа дараа тавьсан боловч шийдвэрлэж өгөөгүй нь ажлын гүйцэтгэлд нөлөөлсөн.
5. “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын 3.1 “Төсвийн ерөнхийлөн захирагч болон төрийн өмчийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч этгээд нь тухайн онд худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайланг журамд заасан маягтуудын дагуу нэгтгэж бичгээр болон файлаар төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад дараах хугацаанд ирүүлнэ.”-д заасны дагуу Сангийн яаманд хугацаанд нь хүргүүлэн ажиллаж байна.
6. Аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хариуг цаг тухай бүр өгч ажиллана. Цаашид зөвлөмж, албан шаардлагын хариуг өгөхдөө хэрэгжилт, үр дүнг тодорхой болгож өгөх тал дээр анхаарч ажиллана.
7. 2020 оны ОНХО-аар бохирын өргөх станцыг бариулж ашиглалтад оруулж, аймгийн ИТХ-ын тогтоолоор УС-ДУ ОНӨААТҮГ-т хүлээлгэж өгсөн. Цаашид бий болсон хөрөнгийг үр дүнтэй ашиглах тал дээр анхаар ажиллах үүрэг чиглэлийг өгч байна.

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛД ӨГӨХ ТАЙЛБАР:

Аймгийн ЗДТГ-аас ирүүлсэн саналтай танилцаад тайлангийн төсөлд дараах байдлаар өөрчлөлт оруулав.

Санал 3,4,6,7-д өгөх тайлбар: Тайлангийн төсөлд өгөх санал бус тайлбар ирүүлсэн тул өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзсэн.

Санал 1-д өгөх тайлбар: Шалгагдагч байгууллагаас ирүүлсэн саналтай танилцаад тайланд дараах байдлаар өөрчлөлт оруулав.

Үүнд: 2021 оны орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр баталсан 20^(Зураг төсвийн задаргаа орсон) төсөл, арга хэмжээнээс аймгийн ЗДҮАХ-т 20 хувь, таван жилийн үндсэн чиглэлд 35 хувь нь тус тус нийцээгүй байна.

Санал 2-т өгөх тайлбар: Шалгагдагч байгууллагын саналыг үндэслэлтэй гэж үзэн асуудлыг бүртгэл болон тайлангаас уг зөрчлийг хассан.

Санал 5-д өгөх тайлбар: Сангийн сайдын 2021 оны 102 дугаар тушаалаар “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам” шинэчлэн батлагдаж худалдан авах ажиллагааны тайлангийн загварт өөрчлөлт орсон байх тул асуудлыг бүртгэл болон тайлангаас хассан.

Хавсралт №1

**2021 онд батлагдсан орон нутгийн хөрөнгө оруулалт нь аймгийн бодлогын баримт
бичгүүдэд нийцсэн эсэхийг тулгасан жагсаалт**

№	Төсөл, арга хэмжээний нэр	Аймгийн Засаг даргын 2020-2024 үйл ажиллагааны хөтөлбөр	Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл
1	Аймгийн төвийн гэрэлтүүлгийн ажил	6.1.6.6	8.1.10
2	Явган зам талбайн ажил	3.6.8.11	8.1.10
3	Найрамдал хотхон 1-р байрны гадна авто зогсоол байгуулах ажил	6.1.6.6	8.1.10
4	Сүмбэр сум 2-р баг, бичил цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилтын ажил	6.1.6.6	8.1.10
5	Нийтийн номын сангийн дээвэр засварын ажил	2.6.6.8	1.1.3
6	Аймгийн Засаг даргын Тамгын газрын контор, грашийн барилгын дээвэр засварын ажил	Нийцэхгүй	Нийцэхгүй
7	Сүмбэр сумын Засаг даргын Тамгын газрын их засварын ажил	4.2.1.1	5.1.1
8	Нийтийн эзэмшлийн байрнуудын цахилгааны щит, монтажийн засварын ажил	6.1.5.5	Нийцэхгүй
9	Ерөнхий боловсролын сургуулийн гал тогооны тоног төхөөрөмж худалдан авах ажил	2.3.7.12	2.1.7
10	Цагдаагийн хэлтэс, Цаг уур орчны шинжилгээний газрын гадна шугам сүлжээ худалдан авах ажил	Нийцэхгүй	Нийцэхгүй
11	Ус-Ду ОНӨААТҮГ-ын зуухны их засварын ажилд шаардлагатай материал худалдан авах ажил	Нийцэхгүй	Нийцэхгүй
12	Мал эмнэлгийн газрын конторын барилгын ажил	4.3.13.19	8.3.4
13	1 дүгээр сургуулийн гадна фасад, заалны дотор засварын ажил	2.3.5.8	2.3.5.8
14	Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажил	3.7.5	8.1.8, 8.1.9
15	Сүмбэр сумын 1 дүгээр багийн 2-р хэлхээний шугам сүлжээний өргөтгөлийн зураг	3.7.9.12	Нийцэхгүй
16	Сүмбэр сумын 1 дүгээр багийн бохир усны шугамын ажлын төсвийг шинэчлэх	3.7.9.12	2.3.35
17	Халуун усны барилга	6.1.7	Нийцэхгүй
18	Усан бассейн бүхий спорт цогцолборын барилгын ажлын төсвийг шинэчлэх ажил	2.2.3.3	2.3.21
19	Шивээговь сумын 3 дугаар цэцэрлэгийн өргөтгөлийн барилгын ажлын төсвийг шинэчлэх ажил	2.3.5.7	2.1.5
20	Найрамдал хотхоны цахилгаан хангамжийн ажлыг төсвийг шинэчлэх ажил	Нийцэхгүй	Нийцэхгүй

Хавсралт №1

**2021 онд батлагдсан орон нутгийн хөрөнгө оруулалт нь аймгийн бодлогын баримт
бичгүүдэд нийцсэн эсэхийг тулгасан жагсаалт**

№	Төсөл, арга хэмжээний нэр	Аймгийн Засаг даргын 2020-2024 үйл ажиллагааны хөтөлбөр	Аймгийг 2021- 2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл
1	Аймгийн төвийн гэрэлтүүлгийн ажил	6.1.6.6	8.1.10
2	Явган зам талбайн ажил	3.6.8.11	8.1.10
3	Найрамдал хотхон 1-р байрны гадна авто зогсоол байгуулах ажил	6.1.6.6	8.1.10
4	Сүмбэр сум 2-р баг, бичил цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилтын ажил	6.1.6.6	8.1.10
5	Нийтийн номын сангийн дээвэр засварын ажил	2.6.6.8	1.1.3
6	Аймгийн Засаг даргын Тамгын газрын контор, грашийн барилгын дээвэр засварын ажил	Нийцэхгүй	Нийцэхгүй
7	Сүмбэр сумын Засаг даргын Тамгын газрын их засварын ажил	4.2.1.1	5.1.1
8	Нийтийн эзэмшлийн байрнуудын цахилгааны щит, монтажийн засварын ажил	6.1.5.5	Нийцэхгүй
9	Ерөнхий боловсролын сургуулийн гал тогооны тоног төхөөрөмж худалдан авах ажил	2.3.7.12	2.1.7
10	Цагдаагийн хэлтэс, Цаг уур орчны шинжилгээний газрын гадна шугам сүлжээ худалдан авах ажил	Нийцэхгүй	Нийцэхгүй
11	Ус-Ду ОНӨААТҮГ-ын зуухны их засварын ажилд шаардлагатай материал худалдан авах ажил	Нийцэхгүй	Нийцэхгүй
12	Мал эмнэлгийн газрын конторын барилгын ажил	4.3.13.19	8.3.4
13	1 дүгээр сургуулийн гадна фасад, заалны дотор засварын ажил	2.3.5.8	2.3.5.8
14	Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажил	3.7.5	8.1.8, 8.1.9
15	Сүмбэр сумын 1 дүгээр багийн 2-р хэлхээний шугам сүлжээний өргөтгөлийн зураг	3.7.9.12	Нийцэхгүй
16	Сүмбэр сумын 1 дүгээр багийн бохир усны шугамын ажлын төсвийг шинэчлэх	3.7.9.12	2.3.35
17	Халуун усны барилга	6.1.7	Нийцэхгүй
18	Усан бассейн бүхий спорт цогцолборын барилгын ажлын төсвийг шинэчлэх ажил	2.2.3.3	2.3.21
19	Шивээговь сумын 3 дугаар цэцэрлэгийн өргөтгөлийн барилгын ажлын төсвийг шинэчлэх ажил	2.3.5.7	2.1.5
20	Найрамдал хотхоны цахилгаан хангамжийн ажлыг төсвийг шинэчлэх ажил	Нийцэхгүй	Нийцэхгүй